

Ч. Чойсамба

**СОРОСЫН ХӨРӨНГИЙГ СОРЖ ГАРСАН НОМ БУЮУ
«ДУНД СУРГУУЛЬД ҮЗЭХ СЭТГҮҮЛ ЗҮЙН ҮНДЭС»-ИЙГ
ДУНД СУРГУУЛЬД ҮЗЭЖ БОЛОХ УУ?**

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сэтгүүл зүйн мэдлэг олгох зорилгоор Монголын Нээлттэй Нийгэм ивээн тэтгэж, «Дунд сургуульд үзэх сэтгүүл зүйн үндэс» хэмээх гоё хавтастай ном хэвлүүлэн гаргасныг сэтгүүл зүйн сургалт, судалгааны ажил эрхэлдэг бид их л нааштай хүлээн авсан юм. Дунд сургуулийнханд сэтгүүл зүйн хичээл ордоггүй, тэдэнд зориулсан сурах бичиг өнөөг хүртэл байгаагүй учир ингэсэн хэрэг. Энэ нь яах аргагүй шинэ зүйл юм. Сэтгүүлч хэмээх нэр хүндтэй мэргэжлийг арван жилийнхэнд сурталчлахад юу нь буруу байхав.

Харамсалтай нь Хелен Ф. Смитийн зохиосон энэ номын хавтсыг эргүүлсэн тэр мөчөөс л урам хугарсан юм. Ядаж л хэн орчуулсан, хэн редакторласныг заасангүй. Цаашлаад хаана, хэдэн хувь хэвлэсэн тухай дурдсангүй.

Энэхүү сурах бичгийн бүтэцтэй танилцахыг хүссэн боловч номонд тавигдах энгийн бөгөөд анхны шаардлага болох гарчиг байсангүй. Иймд номын 96 хуудсыг бүрэн эргүүлж байж л ойлголт авлаа.

Гарчиг нь хүртэл үг үсгийн алдаатай болсныг операторчийн буруу гэж үзэн, хөндөлгүй орхиё. Тус сурах бичиг (хэрэв ингэж нэрлэж болох юм бол): 1. Сурвалжлага, 2. Бичих, редакторлах (хянах), 3. Хэвлэлийн компьютер график, 4. Бизнес үйл ажиллагаа гэсэн дөрвөн хэсгээс бүрдэх аж. Гүйлгээд харсан ч арван жилийн сурагчдад редакторлах арга барилыг заах, хэвлэлийн компьютер графиктай танилцуулах, тэр тусмаа менежментийн нарийн асуудал руу орж, бизнес үйл ажиллагааны тухай өгүүлэх нь оновчгүй болох нь тодорхой. Тэгээд ч дунд сургуульд үзнэ гэсэн тодотголтой атлаа оюутнуудад хандаж бичигдсэн нь ойлгомжгүй юм.

Харамсалтай нь энэ номонд сэтгүүл зүй гэж чухам ямар институт болох, ямар зарчимд тулгуурлаж, ямар үүрэг гүйцэтгэдэг тухай, өөрөөр хэлвэл, номын нэрэнд орсон тэр «үндэс»-ийн тухай нэг ч өгүүлбэр алга. Энэ нь газар зүй гэж ямар шинжлэх ухаан болох, юу судалдаг талаар өгүүлээгүй атлаа тив, бүс гээд заахтай адил.

Тус ном бүхэлдээ сургуулийн сонины тухай үндсэн мэдэгдэхүүн олгоход чиглэгджээ. Энэ нь дунд сургууль байтугай их, дээд сургуулиудад ч тэр бүр сонингүй байгаа манай оронд зөөлөн хэлэхэд арай эртэдсэн, нүдээ олоогүй хэрэг юм. Бааз, суурь нь байхгүй атал энэ тухай мэдлэг олгох оролдлого нь арван жилийн сурагч байхад тохиолдсон нэг явдлыг санагдуулсан. Бидэнд

компьютерийн үндэс гэдэг хичээлийг компьютергүйгээр, самбар дээр зурж тайлбарлан зааж байсан юм.

Одоо номын агуулга руу орёе. «Сурвалжлага» гэсэн хэсэгт сурвалжлага гэж чухам юу болох тухай нэг ч үг алга. Энэ хэсгийн эхний арван өгүүлбэрт «сурвалжлага» гэдэг үг тохиолдоогүй нь бас гайхалтай. Тус хэсэг «*Сайн мэдээ хэвлэх нь редакцийн эрч хүч, зоригийг илтгэж мэдээллийн шуурхай байдлыг хангаж чаддаг*» (4-р тал) гэж эхэлж байгаа нь бүр ч гайхал төрүүлэв. Ер нь энэ номонд нэг ч тодорхойлолт тааралдаагүйг зориуд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал: «мэдээ» хэмээх бичлэгийн зүйлийг «*Сонин сэтгүүлийн гол нь сайн мэдээ бөгөөд цагт нь мэдээлэхийг чухалчлах ёстой*» (10-р тал) гэж тодорхойлсон нь дэндүү утгагүй, дэндүү шинжлэх ухааны бус болжээ. «Сурвалжлага», «мэдээ» гэж юу болохоо тайлбарлаагүй байж сурагчдаар сурвалжлага, мэдээ бичүүлэх нь томъёогий нь хэлээгүй байж тэднээр математикийн, физикийн, эсвэл химийн бодлого бодуулахтай агаар нэг юм.

Мөн «Feature coverage» гэсэн дэд хэсэг байгаа юм. Чухам юуг ингэж нэрлэдэг талаар сурах бичигт «*feature нь хүнийг боловсруулах, өдөөх эсвэл зүгээр л зуугаатай байж болно*» (13) гэжээ. Чухам юу гэж хэлэх гэсэн нь тайлагдашгүй оньсого. Арай Хелен Ф. Смит ийм зүйл бичмээргүй. Номын тухайд ерөнхийд нь дүгнэн хэлэхэд, монгол хэлээр бичигдсэн ч монгол хүнд ойлгомжгүй ном болжээ. Түүнчлэн «*News page оруул*» (14), «*Stress timelines*» (20) зэрэг дэд хэсэгт энэ тухай цухуйлгасан ч үгүй. Иймэрхүү жишээ олныг татаж болно. Ер нь сурах бичигт ингэж гадаад үг хэллэг ямар ч орчуулгагүй оруулах шаардлага бий гэж үү? Энэхүү номыг сэтгүүл зүйн анхан шатны ойлголтгүй, дээр нь сурган хүмүүжүүлэх ямар ч мэдлэггүй хүн орчуулсан нь эндээс илэрхий харагдаж байна. Тиймдээ ч нэрээ тавихаас эмээсэн болов уу.

Англи хэлний тухайд гэвэл цэцэрхэл, чамирхал төдий зүйл үлэмж оржээ. Жишээлбэл: «*ойр тойрон (community)*» (23), «*гажууг (bias)-г багасгахын тулд*» (30), «*тэнцвэрт өгүүлбэр (a balanced sentence)*» (33), «*үзэл бодлыг гаргах (opinion pieces)*» (53) гэх зэргээр шаардлагагүй газар гадаад үг хэллэг их хэрэглэсэн байна. Ойр тойрон, гажуу, тэнцвэрт өгүүлбэр, үзэл бодлыг англиар юу гэдэг нь сэтгүүл зүй үзэх сурагчдад чухал биш. Зарим газар орчуулгагүй англи үг хэллэг оржээ. «*Мөрүүд hyphen-р дуусах ёсгүй*» (59) гэсэн байх юм. Hyphen гэж юу байдгийг мэдэхгүй хүний хувьд энэ өгүүлбэр байхгүйтэй адил.

Орчуулагч заримдаа ноцтой гэмээр алдаа гаргасныг дуугүй өнгөрүүлж болохгүй нь. «*Сургуулийн редакторууд өөрийн анхдагч уншигч болох сурагчдыг мэдэж тэдэнд хандаж бичих хэрэгтэй*» (4) гэснийг уншихад сургуульд редакторууд байдаг, тэд сонинд юм бичдэг юм байна гэж ойлгохоор болжээ. «*Сонин нь мэдээ нийтэлдэг учраас ямагт шинэ соргог байх ёстой*» (69) гэсэн өгүүлбэрийг уншихад сонин мэдээ л нийтэлдэг мэт ойлголт төрнө.

«Нэг асуудлыг олон сэдвээр өргөжүүлэн бич» (13) гэсэн нь хачирхалтай. Нэг асуудлыг олон сэдвээр бичиж болох уу? Энэхүү номыг орчуулагч л ингэж бичиж чадах байх. Харин нийтлэлч хүн нэг асуудлыг олон талаас нь бичнэ.

Зарим нэг зөвлөгөө ямар ч утгагүй, практик ач холбогдолгүй болжээ. Америк эрдэмтэн маань ийн зөвлөжээ: «Жишээ нь, багшийн тухай өгүүлэл нь тухайн багш хэвлэл гарах өдөр юм уу түүнээс хойхоно юу хийж байх нь вэ, гэдэг мэдээллийг агуулсан байх ёстой» (14). Хэрэв иймэрхүү маягаар сонины хуудсыг дүүргээд байвал тэр хэвлэл удахгүй амьсгалаа хураах нь тодорхой. Түүнчлэн «Хуудсанд дизайн хийхийн өмнө бүх зургуудыг гартаа оруулах ёстой. Ийм маягаар гол зүйлүүдийг зөв урсгалд оруулна» (79) гэжээ. Галзуу хүний өдрийн тэмдэглэл гэж үүнийг л хэлэх байх. Магадгүй, орчуулагч ойлгохгүй зүйлүүдээ хаяад явчихсаны уршгаар ийм «бүтээгдэхүүн» төрсөн байж ч болно.

Эл сурах бичигт нийт 23 зураг хавсаргажээ. Үүнээс ердөө 4 нь тайлбартай байна. Гэтэл зургийг тайлбарлаж байх ёстой гэж сургамжилсан нь бий. Зарим зураг ямар учиртай, юу дүрсэлсэн нь ойлгомжгүй. 1-р нүүрэнд учир битүүлэг англи гар бичмэл хавсаргажээ. Өмнөх үгийг уншиж үзвэл Америкийн сургуулийн анхны сонин бололтой. 35-р нүүрэнд засварын тэмдэгтүүдийг оруулжээ. Уг нь хэрэгтэй боловч англи хэл дээр байгаа нь тоогүй. Редакторлахад ямар тэмдгийг ямар тохиолдолд хэрэглэдгийг монгол хэвлэлийн жишээн дээр тайлбарласан бол зөв байсан юм. Ядаж л орчуулчихсан бол өөр хэрэг.

Зарим хэсэг өөрөө өөрийгөө няцааж байна. «Хэл найруулгын ном хэрэглэ» дэд хэсэгт «Хэвлэл бүрийн найруулга өөрийн гэсэн онцлогтой байх ёстой бөгөөд редакторууд түүнийг тогтвортой хадгалах ёстой» (34) гэж, үг нурших алдаа гаргажээ. Иймэрхүү жишээ олон байгаагийн дээр хэл найруулгын тухай өгүүлсэн хэсэг өөрөө алдаагаар дүүрсэн нь зохимжгүй. «Цэг таслалыг зохих газар нь зөв хэрэглэ» дэд хэсэгт орчуулагч «хашлага» хэмээх шинэ тэмдэгт гаргажээ. Зүй нь хашилт юм. Мөн «Цэг таслалыг хэрэглэх ерөнхий сайн дүрэм бол, тэднийг аль болох бага хэрэглэх явдал юм» (34) гэсэн байх юм. АНУ-д л ийм байдаг юм болов уу. Монголд цэг, таслалыг зохих газар нь тавьдаг. Хэрэв «аль болох бага хэрэглэх» юм бол тэмдэгтийн алдаанд хүргэдэг. «Цэг таслалыг хэтрүүлэн хэрэглэх нь буруу, ялангуяа гарчигт» (34) гэсэн атлаа гарчгуудын ард цэг тавиад явсан нь зөрчилтэй болжээ. Нэгэнт л гарын авлага гаргаж байгаа юм бол ядаж өөрөө тэр дүрмээ баримталмаар. Гэтэл гарчгийн ард цэг тавьдаггүй дүрэмтэй. Эдгээр зөвлөгөөнүүдэд «олон тооны хамааруулах төлөөний үгэнд апострофын алдаануудыг арилгах» (34) гэсэн нь апостроф байдаггүй монгол хэлэнд зохихгүй юм. Мөн хамааруулах төлөөний үг гэж үгийн шинэ аймаг гаргажээ. 32-р нүүрэнд «он сарын дагаврыг бүү хэрэглэ (On Mondays/ Mondays)» гэжээ. Мөн л угтваргүй (орчуулагчийнхаар бол дагавар) монгол хэлэнд тохирохгүй. Эсвэл гадаадын сонинд материал

бичих тийм чадвартай боловсон хүчнийг бэлтгэж байгаа юм уу? Бид гадаадын ном зохиолыг орчуулж болно. Гагцхүү монгол хөрсөнд тэрхүү номын үрийг суулгаж чадах ёстой. Ингэж чадаагүй тохиолдолд орчуулга амьдралаас тасархай, үр дүнгүй, практик ач холбогдолгүй болдог.

Ер нь хэл найруулгын хувьд энэ номтой «Берлиний төлөө тулалдаан» зарлаж болохоор. Берлиний төлөө тулалдаанд гудамж, байшин болгоны төлөө байлдсан шиг тус номын өгүүлбэр болгоны найруулгыг цэгцлэх хэрэгтэй байна. Найруулга гэдэг бол аливаа нийтлэл, ном, зохиолыг уншигчдад энгийн, ойлгомжтой, хүртээмжтэй, цэгцтэй хүргэх гол хөшүүрэг юм. Гэтэл аливаа бичмэл материалд тавигдах энэхүү анхан шатны шаардлага өгүүлбэр, мөчлөг болгонд зөрчигджээ. Хэсгийн гарчгийг аваад үзсэн ч «редакторлах» гээд хаалтанд «хянах» гэсэн нь (2-р хэсэг) эл хоёр үг утга дүйх мэт ойлголт төрүүлж байна. Уг нь редакторлах үйл ажиллагааг зөвхөн хянахаар хязгаарлаж болмооргүй. Энэ бол өргөн утгатай ойлголт. «Том үсгээр эхэлсэн үг, цэг таслалыг цөөл» гэж сургамжилжээ (60). Буруу найруулсны улмаас цэг, таслал нь том үсгээр эхэлдэг юм шиг болжээ.

Сэтгүүл зүйн суурь ойлголттой харшилсан зүйл ч цөөнгүй тохиолдлоо. «Мэдээг бичихдээ зохиогч эхлээд гол зүйлийг гаргаж тайлбарлаад, дараа нь хоёрдогч, гуравдагч баримтуудыг тавих хэрэгтэй... Ийм бүтэцтэй мэдээг оройг нь уруу харуулсан пирамид гэж нэрлэдэг бөгөөд хамгийн чухал бус, ер нь хуучин гэхээр баримтаар дууссан байх ёстой» (46) гэжээ. Шинэлэг байх чанараараа ялгардаг мэдээг хуучин баримтаар төгсгөнө гэдэг нь гайхалтай. Уруугаа харсан пирамид бүтцийг (орчуулагчийн хэлснээр, оройг нь уруу харуулсан пирамид) ийм болхи аргаар тайлбарлах нь дэндүү өрөвдөлтэй бөгөөд аргагүй л мэргэжлийн хүний зөвлөгөө дутагдсаных.

Зарим газар утгагүй, авцалдахгүй зүйрлэл, харьцуулал хийхийг оролджээ. Жишээлбэл: «Мэдээ товч байдгийн нэгэн адил гэрэл зургууд нь зөв засвартай байх ёстой» (78) гэжээ. Уг өгүүлбэрт мэдээний товч байдлыг зургийн засвартай харьцуулсан байна. Энэ нь угтаа туулайны хурдныг илжигний зөрүүдтэй адилтгасан хэрэг болжээ. Зүй нь аливаа хоёр зүйлийг ижил төстэй чанараар нь адилтгамаар.

Урьд өмнө сэтгүүл зүйд хэрэглэгдэж байгаагүй нэр томъёонууд олноор тааралдаж байна. «Гэнэтийн мэдээ» (45) гэсэн байх юм. Чухам юуг ийн нэрлэсэн нь нь таавар. Тэрхүү хэсэг «Эхний хэсэгт дэс дарааг сайн өгч чадвал өгүүллийн үлдсэн хэсэг нь бараг аяндаа бичигдэнэ» гэж эхэлжээ. Ер нь гарчигт тэмээ гэхийгээд, эх бичвэрт ямаа гэх нь энэ номын хувьд энгийн үзэгдэл юм. Тэгээд ч өгүүллийн зөвхөн эхний хэсэгт дэс дараа хэрэгтэй, дунд хэсэг, төгсгөлд хэрэггүй юм шиг сэтгэгдэл төрж байна.

Зарим өгүүлбэрийг хэд уншсан ч үл ойлгогдоно. Тухайлбал: «Мэдээний нүүр бүр шууд утгыг илэрхийлсэн, мэдээлэл өгөх зэрэг онцлогтой байна» (72) гэжээ. Тэгэхлээр мэдээнд нүүр байдаг болж таарах нь. Бас шууд утгыг

илэрхийлдэг аж. Мөн «Сонины нүүр бүрийн эхлэл нь ойлгомжтой, амьд байх ёстой» (68) гэсэн байх юм. Юу гэж байгаа юм бүү мэд. Ямар ч гэсэн монголоор бичсэн нь маргаангүй.

«Шинэ мөрний хэмжээг тохируулах хэрэгтэй» дэд хэсэгт «М үсгийн хэмжээтэй зай авах нь хамгийн тохиромжтой» (70) гэжээ. Гэтэл сурах бичгээ үзвэл догол мөрүүд (шинэ мөр гэж өвөрмөцөөр нэрлэжээ) харилцан адилгүй зайтай, зарим газар ямар ч зайгүй авсан байх жишээтэй. Үүнээс үзвэл орчуулагч маань төрөлх хэлээ ч муу мэддэг хүн бололтой.

Эцэст нь хэлэхэд, ийм номыг дунд сургуульд үзэж болох уу? Энэ асуултын хариултыг би нээлттэй орхиж байна. Уншигчийн мэргэн оюун шийдэх биз. Нэг айх юм гэвэл ийм сурах бичгээр сэтгүүл зүй хэмээх сонирхолтой салбарт анхны алхмаа хийсэн охид, хөвгүүд сэтгүүл зүйгээс цэрвэх вий.

Ийм нэг номыг Монголын Нээлттэй Нийгэм буюу Соросын сан ивээн тэтгэж хэвлүүлжээ. Уг нь монголчуудад хэрэгтэй нэг ч гэсэн ном гардагсан бол их л тустайсан.

Энэ номыг орчуулсан хүн нэрээ тавиагүй нь их учиртай. Орчуулсан нь бүр ч их учиртай. Америкийн нэг эмэгтэйн номыг орчуулж, хөрөнгө цацаж байснаас өөрийн орны эрдэмтдээ хамруулсан бол... Энэ номыг уншихад Монголд тохирохгүй маш олон зүйл тохиолдоно. Гэсэн ч «нууц эзэд»-эд нь энэ падгүй. Хамгийн гол нь муу ч бай, сайн ч бай ном гаргасан. Энэ номыг Сорос, үгүй гэхэд түүний сангийн Монгол дахь гүйцэтгэх захирал ноён Крис Финч ямар уншиж чадах биш. Харин монголчууд уншаад юу гэх нь орчуулагчдад чухал биш.

Айлаас эрэхээр авдраа уудал гэсэн сайхан монгол үг бий. Гэхдээ хамгийн гол нь авдраа уудлуулах шаардлага Соросын сангийн монгол ажилтнуудад байхгүй. Яагаад гэвэл ингэсэн тохиолдолд тэдэнд ногдох хувь эрс багасна. Ийм учир гадаадын зээл, тусламж монголчуудад хүрэхгүй, тэднийг тойрч байна. Ийм учир гадаадын нэгэн бээрийн ном Монголд орчуулагдаж, жорлонгийн цаас болон хувирч байна. Ийм учир гадаадууд оролцсон хурал семинар Монголд моодонд орж, нийгмийг хөгжүүлэх гол хүчин зүйлийн хэмжээнд тавигдаж байна. Хөрөнгө урссаар... Харин ахисан зүйл үгүй. Үүний оронд сэтгүүл зүйн мэргэжлийн багш нар монгол жишээ, баримттай гарын авлага бэлдсэн бол мөнгөнд ч хэмнэлттэй, оюутан, сурагчдад ч тустайсан.

Манайхан сайхан сэтгэлийн үзүүрт тос гэдэгсэн. Харь элгийн боловч халуун сэтгэлээр монгол түмний минь оюуны санд «тос хураасан» хүний итгэлийг арын хаалга, танил талаараа хуваадаг монгол түшмэд хөсөрдүүлж байх шиг...